

# ХАНБОГД СУМЫН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Их булаг

2014 он 02 сарын 07 өдөр

Ханбогд сумын зарим малчдаас Оюу Толгой төслийн сөрөг нөлөөллийн талаар Дэлхийн банкны дэргэдэх гомдол хүлээн авдаг байгууллага (ombudsman)-д 2013 онд гомдол гаргасан билээ. Гомдлын мөрөөр эвлэрүүлэн зуучлагчийн багийг Ombudsman-с томилсон бөгөөд малчид өөрсдийн төлөөлөгчдийг сонгосон. Оюу Толгой Хяналт ТББ малчдад зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Эдгээр талууд тогтмол уулзаж, гомдлын асуудлаар хэлцэл хийдэг бөгөөд 2014 оны 2-р сарын 7-ны өдөр Ханбогд суманд ээлжит уулзалт болов. Энэ үеэр Оюу Толгой уурхайн үйл ажиллагаатай холбоотой тоосжилт, малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг үнэлэх Олон талт мэргэжлийн шинжээчдийн багийг ажиллуулах болон тус суманд зохион байгуулж буй уулзалтуудад Эрдэнэс Оюу Толгой ХК-ийн төлөөллийг оролцуулах тухай дэлгэрэнгүй хэлэлцэв. Энэ уулзалтад шинээр сонгогдсон малчдын төлөөлөгч нар оролцсон болно.

Малчдын төлөөлөгчдийн зүгээс Оюу Толгой уурхайн үйл ажиллагаанаас үүдэн тоосжилт ихсэж байгаа тухай ярьж, Оюу Толгой компани энэ тал дээр ямар арга хэмжээ авч байгаа талаар танилцуулж, эдгээр арга хэмжээнд малчдыг оролцуулах, мэдээллийг харилцан солилцож байхаар тохиров. Мөн компанийн зүгээс тоосны талаар 2014 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг иргэдэд хүргүүлэхээр болов. Малчдын төлөөлөгчид Оюу Толгой компанийн хэрэгжүүлж буй нүүлгэн шилжүүлэлт, нөхөх олговрын хөтөлбөрт шүүмжлэлтэй ханддаг ба хөтөлбөрт уурхайн үйл ажиллагаанаас нутгийн малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг бэлчээр ашиглалттай уялдуулаагүй, тэдгээрийн тогтвортой амьжиргаанд нөлөө үзүүлж байна гэж үзсэн. Иймд урьд нь тохиросны дагуу олон талт мэргэжлийн шинжээчээр дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэдэг дээр талууд санал нийлэв. Уг багийн ажлын удирдамжийг болон ажлын даалгаврыг талууд тохирох бөгөөд мэргэжилтнийг сонгон шалгаруулах ажлыг ч хоёр тал хамтран гүйцэтгэх юм.

Ханбогд сумын малчдын төлөөлөл  
Оюу Толгой ХХК